

АРХАНГАЙ АЙМГИЙН УС, ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
АЛБАН ХААГЧДЫН СУРГАЛТЫН ХЭРЭГЦЭЭГ ХАНГАХ
2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

№	Сургалтын чиглэл	Сургалтад оролцогчид	Сургалтын хугацаа	Хугацаа, хоногоор	Сургалтанд хамрагдах ажилтны тоо	Сургалтын хэлбэр	Хэрэгжилт
1	2	3	4	5	6	7	8
Нэг. Ажлын байран дахь сургалт							
1.	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх	Ус, цаг уурын өртөө, харуулын ээлжийн техникч, харуулын ажиглагч нар болон бусад ажилтан	Тухай бүр	Төлөвлөсөн хугацаагаар	68	Танхим болон цахим	2024 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар ус судлалын 10 харуул, ХААЦУ-ын 17 салбарт хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг 1 удаа, нийт 68 албан хаагчид өгсөн байна. Байгаль орчны шинжилгээний лабораторид Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажлын байран дахь зааварчилгааг тогтмол өгч хэвшсэн.
2.	Орлон ажиглагч бэлтгэх сургалт	Орлон ажиллах иргэд	Тухай бүр	10 хүртэл хоног	Тухай бүр	Танхим	Өндөрүлаан, Хайрхан, Хашаат, Чулуут, Төвшрүүлэх, Эрдэнэмандал, Өгийнуур сумдад цаг уурын ажиглагч болон орлон ажиглагч, Эрдэнэбулган сумын Урдтамир усны ажиглагч, Тариат сумын Гичгэнэ-Тариат усны ажиглагч нарыг бэлтгэн, сургаж дадлагажуулсан.
3.	Чиглүүлэх болон дадлагажуулах сургалт	Шинээр ажилд орж байгаа болон шилжин ажиллаж байгаа ажилтан	Тухай бүр	5 хоног	Тухай бүр	Танхим	1 дүгээр сард БОШЛ-ын инженер Б.Гантулга нь БОШЛ-ын инженерийн мэргэшүүлэх 21 хоногийн сургалт, БНСУ-д БОШЛ-ийн технологич инженер М.Чулуунхүү “ICT- мэдээлэл холбоо, харилцааны технологид суурилсан Агаарын чанарын хяналтын нэгдсэн системийн сургалт”-д 02 дугаар сарын 18-25-ны өдрүүдэд тус тус хамрагдсан. Хөдөө аж ахуйн цаг уур болон урьдчилан мэдээлэхийн инженерээр шилжин ажиллаж байгаа 2 албан хаагчийг дадлагажуулах сургалтыг 5-21 хоногийн хугацаанд тухайн чиглэлийг хариуцсан албан хаагчид батлагдсан хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан. Мөн уур амьсгал, хөдөө аж ахуйн цаг уурын ахлах техникч Б.Мөнхбулган нь ЦУОШГ-ын УМХ-т 1

1	2	3	4	5	6	7	8
							сарын хугацаанд дагалдах, чиглүүлэх сургалтад хамрагдсан. Тариат сумын Гичгэнэ-Тариат усны ажиглагчийн ажлын байранд 1 иргэнийг 2024 оны 05 дугаар сард бэлтгэж туршилтаар ажиллуулж томилсон.
Хоёр. Мэргэшүүлэх сургалт							
4.	Мэргэжлийн чиглэлээр сургалт зохион байгуулах	Сумдын өртөөдийн ээлжийн техникч, Гадаргын ус судлал, Хөдөө аж ахуйн цаг уурын харуулын ажиглагч нар	03 дугаар сарын 27, 28-ны өдрүүдэд	2	43	Танхим болон цахим	Сумдын ус, цаг уурын өртөө, харуулын ажиглагч, техникч нарт 03 дугаар сарын 30-ны өдөр цахим сургалт, 10 дугаар сарын 24-25 өдрүүдэд танхимын сургалтыг тус тус зохион байгуулсан.Сургалтын ирц 100 хувь.
5.	ЦУОШГ-ын сургалтын төлөвлөгөөний дагуу зохион байгуулах сургалтад оролцох	Хамаарал бүхий ажилтан, албан хаагч	Тухай бүр	Төлөвлөсөн хугацаагаар	Хамаарал бүхий ажилтан, албан хаагч	Танхим болон цахим	Нислэгийн цаг уурын төвөөс зохион байгуулсан “Нислэгт цаг агаарын урьдчилсан мэдээгээр үйлчлэх” эрх бүхий албан хаагчдад зориулсан давтан сургалтад урьдчилан мэдээлэхийн инженер С.Мөнхтөр 04 дүгээр сарын 29-ний өдрөөс 05 дугаар сарын 04-ний өдрийг хүртэл хугацаанд хамрагдсан.
6.	Ус, цаг уурын ажиглагчийн чадамж эзэмшүүлэх сургалтад хамруулах	Ус, цаг уурын өртөө, харуулын ээлжийн техникч, харуулын ажиглагч нар	ЦУОШГ, Ус цаг уурын Сургалт зохион байгуулах	21	ЦУОШГ-аас ирсэн хөтөлбөрийн дагуу	Танхим	Цаг уур орчны шинжилгээний газарт 11 дүгээр сарын 04-нд Ус, цаг уурын ажиглагчийн чадамж эзэмшүүлэх сургалтад хамруулах 5 албан хаагч (Ш.Чойням, У.Даариймаа, И.Пүрэвдулам, Д.Жавзандулам)-ийн нэрийг хүргүүлсэн.Сургалт зарлагдаагүй байна.
Гурав. Туршлага солилцох арга хэмжээ болон бусад чиглэлээр							
7.	Аймгийн ЗДТГ, бусад төрийн болон төрийн бус байгууллага, төсөл хөтөлбөрийн сургалт	Хамаарал бүхий ажилтан, албан хаагч	Сургалт зохион байгуулагдсан тухай үед нь оролцох	Тухайн сургалтын хугацаагаар	Тухайн сургалтад оролцох хүний тоогоор	Танхим болон цахимаар	Аймгийн “Насан туршийн суралцахуйн төв”-ийн 21 удаагийн сургалтад давхардсан тоогоор 378 албан хаагч, АЗДТГ, бусад төрийн болон төрийн бус байгууллага, төсөл хөтөлбөрийн сургалтад холбогдох албан хаагчдыг бүрэн хамруулсан.Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 вебинар сургалтад бүх албан хаагчид тогтмол хамрагдаж хэвшсэн.

1	2	3	4	5	6	7	8
8.	ЦУОШГ болон аймгуудын УЦУОШТ-өөс зохион байгуулах сургалтууд	Хамаарал бүхий ажилтан, албан хаагч	Сургалт зохион байгуулагд сан тухай бүр нь оролцох	Тухайн сургалтын хугацаагаар	Тухайн сургалтад оролцох хүний тоогоор	Танхим болон цахим	БОУАӨЯ, ЦУОШГ-аас зохион байгуулсан нийт 6 удаагийн сургалтад давхардсан тоогоор 66 албан хаагч хамрагдсан байна.

АРХАНГАЙ АЙМГИЙН УС, ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН АЛБАН ХААГЧДЫН
НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

№	Хийх ажил	Хугацаа	Хэрэгжилт
1	2	3	4
Зорилт 1: Албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүрэг, хөдөлмөрийн гэрээнд заасан эрх, үүрэг, гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах ажлын байр, эрүүл ахуйн нөхцөл, бичиг хэргийн хэрэгсэл, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаанд нийцсэн техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, эд материал, ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл, мэдээллээр хангах зорилтын хүрээнд:			
1.	Ажлын байрны дотоод орчныг тохижуулж, эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх	Жилдээ	Цэцэрлэг өртөөний ширээ, ор, шүүгээг шинэчилж, архивын өрөөг холбогдох стандартад нийцүүлэн тохижуулсан.Багажийн инженер, сүлжээний инженер, ус, цаг уурын ажиглагч нарыг хөдөлмөр хамгааллын бээлий, хувцас, борооны цув, гар чийдэнгээр хангалаа. Байгууллагын өрөө, тасалгааны 9 разеткуудыг шинэчилж аюулгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлж байна. Хөмрөг үүсгэгч архивын өрөөг стандартанд нийцүүлэн хаалгыг төмөрлөн, галын аюулгүй байдлыг ханган галын хор, элс, хүрз зэргийг өрөөнд байршуулсан.
2.	Албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, эд хогшил, техник хэрэгслээр хангах	Тухай бүр	-Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын багцаас шийдвэрлэгдсэн 129.2 сая төгрөгөөр Цаг уурын өртөө, харуулын компьютерийг бүрэн шинэчлэж, мөн байгууллагын албан хэрэгцээнд шаардлагатай байгаа техник хэрэгслүүдийг худалдан авч, цаг уурын 4 өртөөнд “ЭКО-00” хийлгэж ашиглалтад оруулаад байна. -Аймгийн Засаг даргын нөөц сангийн 19.0 сая төгрөгөөр архивын нягтруулсан шүүгээ худалдан авч ашиглалтад оруулсан. -11 дүгээр сард 1 ком нумыг 495.000 төгрөгөөр авч автомашинд суурилуулан хэвийн ажиллагааг хангасан. -Мэдээлэл үйлчилгээний хэлтсийг телефон утас, принтер, мөн БОШЛ-ийг принтерээр, Эрдэнэмандал, Тариат, Төвшрүүлэх өртөөдийг принтер, хор, бичгийн цаасаар тус тус хангасан.
Зорилт 2: Албан хаагчдыг хууль тогтоомжоор олгогдсон нийгмийн баталгаагаар бүрэн хангах, хөдөлмөрийн дотоод журамд заасан дэмжлэг, тусламж, тэтгэмжийг үзүүлэх зорилтын хүрээнд:			
1.	Албан хаагчдын цалинг ажилласан жилийг харгалзан нэмэгдүүлэх, мэргэшлийн зэрэг, ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх	Жилдээ	2024 оны 11 дүгээр сарын гүйцэтгэлээр 68 албан хаагчид алба хаасан хугацааны нэмэгдэл 110,244.5 мянган төгрөг, 16 албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл 19,385.5 мянган төгрөг, 37 албан хаагчид ур чадварын нэмэгдэл 26,362.8 мянган төгрөгийг тус тус хууль тогтоомжийн дагуу олгосон байна.

1	2	3	4
2.	Хоол, нийтийн тээврийн унааны зардлыг байгууллагын дотоод журмын дагуу тухайн жилийн төсөвтэй уялдуулан олгох	Жилдээ	Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын дагуу төвийн албан хаагчдад хоол унааны зардлыг өдрийн 23,000 төгрөгөөр, сумдын албан хаагчдад хоолны зардлыг өдрийн 10,000 төгрөгөөр тооцон олгож байгаа бөгөөд 11 дүгээр сарын гүйцэтгэлээр нийт 233,974.1 мянган төгрөг олгосон байна.
3.	Хөдөлмөрийн хортой нөхцөл, шөнийн болон илүү цагаар ажилласан, орон нутагт ажилласны нэмэгдэл хөлсийг хууль тогтоомжид заасны дагуу олгох	Жилдээ	2024 оны 11 дүгээр сарын гүйцэтгэлээр БОШЛ-ийн 3 албан хаагчид хөдөлмөрийн хортой нөхцлийн нэмэгдэл 3,830.2 мянган төгрөг, 20 албан хаагчид шөнийн цагийн нэмэгдэл 21,496.2 мянган төгрөг, 33 албан хаагчид илүү цагийн нэмэгдэл 67,904.1 мянган төгрөг, 68 албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл 187,938.6 мянган төгрөгийг тус тус олгосон байна.
4.	Орон нутагт томилолтоор ажиллах албан томилолтын зардлыг олгох	Тухай бүр	2024 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар албан томилолтоор ажилласан 32 албан хаагчид 3,371.0 мянган төгрөгийн албан томилолтын зардлын олгоод байна.
5.	Ажлын байрны чиг үүргийг оновчтой тодорхойлох, ачааллыг жигдрүүлэх, албан хаагчдын ажлыг холбогдох журмын дагуу үнэлж, урамшуулах ажлыг зохион байгуулах	Хагас, бүрэн жилээр	2024 оны эхний хагас жилийн албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлж төвийн даргын тушаалаар хэвийн болон маш сайн үнэлэгдсэн 48 албан хаагчид 46,620.9 мянган төгрөг олгосон бөгөөд албан хаагчдын жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг нэгтгэх, дүгнэх ажил холбогдох журмын дагуу хийгдэж байна.
6.	Төрийн албан хаагчийн ээлжийн амралтыг биеэр эдлүүлэх, ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй албан хаагчид хөдөлмөрийн хуульд заасны дагуу ээлжийн амралтын цалинг нэг аравны тав дахин нэмэгдүүлж олгох	Жилдээ	Нийт албан хаагчдын 2024 оны ажлын жилийн ээлжийн амралтын хуваарийг төрийн албан хаагчдаас саналыг нэгтгэн авч баталсан. 2024 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар нийт албан хаагчид хуваарийн дагуу “Мэдэгдэх хуудас”-аар 2024 оны ажлын жилийн ээлжийн амралтаа эдлээд байна. Цэцэрлэг ХААЦУ-ын харуулын ажиглагч Л.Бадамханд, Хангай ХААЦУ-ын харуулын ажиглагч Ч.Энхжаргал нарын ээлжийн амралтын хугацаанд орлон ажиллах хүнгүй учраас дотоод журмын дагуу 1 сарын хугацаанд ээлжийн амралтыг олгож, биеэр эдэлж чадаагүй ээлжийн амралтын цалинг хөдөлмөрийн тухай хуулийн дагуу 1.5 дахин нэмэгдүүлэн олгосон.
7.	Албан хаагчдын ажил үүргээ үр дүнтэй биелүүлж, гаргасан амжилт, идэвх зүтгэлийг үндэслэн төрийн дээд одон медаль, Байгаль орчин, аялал, жуулчлалын яамны тэргүүний ажилтан, жуух бичиг, Цаг уур, орчны шинжилгээний газрын жуух бичиг болон бусад салбарын шагналд тодорхойлох, тус төвийн шагналаар шагнах, мөнгөн шагнал, эд зүйл дурсгах	Жилдээ	Монгол улсад Ус, цаг уурын байгууллага үүсч хөгжсөний түүхт 100 жилийн ойг угтан төрийн дээд одон медальд 3 албан хаагч, “Байгаль орчны тэргүүний ажилтан”-аар 13 (11 нь авсан) албан хаагч, БОАЖЯ-ны “Жуух бичиг”-т 9 (8-нь авсан) албан хаагч, ЦУОШГ-ын “Жуух бичиг”-т 5 (4 нь авсан) албан хаагчийн нэрийг дэвшүүлэн тодорхойлж, холбогдох баримт бичгийг ЦУОШГ-т хүргүүлснээр нийт 26 албан хаагч шагнуулсан. Үүнээс 12 албан хаагч 100 жилийн ойн арга хэмжээний үеэр шагналаа гардан авсан.
8.	Албан хаагчдад Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу тусламж, дэмжлэг, тэтгэмж, нөхөн олговор олгох	Тухай бүр	Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу нийт 16 албан хаагчид 3-5 ажлын өдрийн цалинтай чөлөө олгосон. 2024 оны төсөвт ажил олгогчоос олгох нэг удаагийн тэтгэмж урамшууллын төсөв батлагдаагүй.

1	2	3	4
9.	Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбоотой байгуулсан Хамтын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж ажиллах	Жилдээ	-Ус, цаг уурын баяраар болон хүүхдийн баяраар 30 хүнд 880.0 мянган төгрөгний гарын бэлгийг олгосон байна. -Эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх эрх-2024 чуулга уулзалтад Цэцэрлэг өртөөний техникч гишүүн М.Эрдэнэчулууныг оролцуулсан. -Аймгийн Тэргүүний ажилтан, Засаг даргын жуух бичиг, өргөмжлөл, хүнс хөдөө аж ахуй байгаль орчны үйлдвэрчний эвлэлийн хорооны тэргүүний ажилтан тэмдгээр тус тус 8 идэвхтэн гишүүд шагнагдсан байна. -Гишүүний татварыг аймгийн ҮЭ-ийн холбооны ХААН банкны дансанд сар бүр шилжүүлж байна. 2024 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар идэвхтэн гишүүд, албн хаагчдаас хөдөлмөрлөх эрхтэй холбоотой зөрчил гараагүй, өргөдөл гомдол ирээгүй.
10.	Албан хаагчдын хүүхдүүдийг “Хүүхдийн баяр”-аар хүлээн авч, бэлэг гардуулж, хүндэтгэл үзүүлэх	6 сард	Байгууллагын дэргэдэх “Хүүхэд гэр бүлийн зөвлөл”, “Залуучуудын зөвлөл”-тэй хамтран төвийн албан хаагчдын 15 хүртэлх насны 43 хүүхдэд гарын бэлэг гардууллаа.
11.	2024 онд өндөр насны тэтгэвэрт гарах 4 албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламжийг холбогдох журмын дагуу олгох	Тухай бүр	2024 онд өндөр насны тэтгэвэрт гарахаар өргөдлөө өгсөн 4 албан хаагчид олгох тэтгэмжийн 111,918.1 мянган төгрөгийн төсөв батлагдсан боловч тэтгэвэрт гарах хугацаагаа сунгах өргөдөл өгсөн 4 албан хаагчийн өргөдлийн дагуу ЦУОШГазарт тэтгэмжийг татуулахаар албан бичиг хүргүүлж шийдвэрлүүлсэн.
12.	“Гэр бүлийн зөвлөл”, “Залуучуудын зөвлөл”-ийг ажиллуулах, үйл ажиллагааг нь дэмжих	Жилдээ	Байгууллагын дэргэдэх “Эцэг эхийн зөвлөл” олон улсын хүүхдийн баярыг тохиолдуулан 0-15 насны хүүхдүүдийн дунд 3 төрөлт тэмцээн зохион байгуулж, шагнаж урамшууллаа.
Зорилт 3: Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, тэдэнд бие бялдар гоо зүйн төлөвшил олгох зорилтын хүрээнд:			
1.	Эрүүл мэндээ хамгаалах, төрөл бүрийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн мэдээ, мэдээллийн булан ажиллуулах	Жилдээ	Мөн “Өглөөний алхалт-Таны эрүүл мэнд”-ын сарын аянд байгууллага хамт олноороо идэвхтэй оролцож 2 дугаар байранд шалгарлаа. Идэвхтэй алхалтын төрөлд Гадаргын ус судлалын технологич инженер Ү.Шүрэнчимэг өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдсан. Биеийн тамир, спортын тухай хууль “Алсын хараа -2050” урт хугацааны хөгжлийн бодлого, засгийн газар болон аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилд төвийн ажилчид хамрагдсан. Эцэг, эхийн зөвлөлийн самбарын эрүүл мэндийн буланд Эмчийн зөвлөгөө, тусламжаар бид хувь хүн болон гэр бүлийн эрүүл мэндийн бүхий л асуудал, өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн мэдээ тогтмол шинэчлэн мэдээлж хэвшсэн.
2.	Албан хаагчдыг спорт заалаар хичээллэх нөхцөл боломжоор хангах, спортын арга хэмжээ зохион байгуулах, оролцуулах, хамрагдах боломжоор хангах	Жилдээ	Байгууллагуудын албан хаагчдын ажлын уялдаа холбоог сайжруулах, нийтийн бие тамирыг хөгжүүлэх, байгууллагын соёлыг бэхжүүлж идэвхтэй хөдөлгөөн, эрүүл мэндийг дэмжиж МУБИС-ийн Архангай аймг дахь Багшийн сургуулийн спорт заалыг түрээслэж 7 хоног бүрийн 2 дахь өдөр 18-20 цагийн хооронд тоглож байна. “Дэлхийн болон Монголын Ус, Цаг уурчдын өдөр” 03 дугаар сарын 22,23-ны өдрүүдэд ажил мэргэжлээ сурталчилан аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Ус, цаг уур, орчны шинжилгээний төв, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Хангайн нурууны БЦГ-ын хамгаалалтын захиргаа, Орхон-Чулуут голын сав газрын захиргаа, Ар-Ус Ундарга ХХК,

1	2	3	4
			Стандарт, хэмжил зүйн хэлтэс, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар гэсэн 8 байгууллагын дунд шилжин явах цомтой шатар, даам, гар бөмбөгийн 3 төрөлт тэмцээнийг зохион байгуулсан. Мөн Төвшрүүлэх сумын цаг уурын албан хаагчид Төвшрүүлэх сумын аварга шалгаруулах тэмцээнд оролцож 2-р байрт орсон. Архангай аймгийн Засаг даргын Тамгын газрын 2024.05.02-ны өдрийн 03/690 тоотын дагуу “Илүүдэл жингүй-Эртэч Монгол” аяны хүрээнд албан хаагчдын эрүүл мэндийг идэвхтэй алхалт, дасгал хөдөлгөөнөр дэмжих зорилгоор алхалтын аянд байгууллагын удирдамж, төлөвлөгөөг гарган төвийн даргаар батлуулан гаргаж байгууллага хамт олноороо идэвхтэй оролцож 2 байр өргөмжлөл мөнгөн шагнал, Алхалтанд хамгийн идэвхтэй оролцогчоор Гадаргын ус судлал хариуцсан технологич инженер Ү.Шүрэнчимэг шалгарч өргөмжлөл мөнгөн шагнал, Нийтийн бүжгийн сургалт, тэмцээнд ХААЦУ-ын технологич инженер Э.Мягмаржаргал, техникч Д.Уранчимэг, Б.Гантулга нар оролцсон. Улаанбаатар хотод 04 дүгээр сарын 23-27-ны өдрүүдэд Монгол улсад Ус цаг уурын алба үүсч хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан зохион байгуулсан 5 төрөлт спортын арга хэмжээнд баг тамирчид оролцож Эмэгтэй шатрын төрөлд Хүний нөөц, хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан ажилтан Д.Гантуул оролцож “МӨНГӨН” медаль хүртсэн. Мөн 2024 оны 06 дугаар 12-ны өдөр “Дэлхийн итгэмжлэлийн өдөр”-ийг тохиолдуулан аймгийн итгэмжлэгдсэн лабораториудын дунд зохион байгуулагдсан 3 төрөлт “Шилжин явах цом”-ын тэмцээнд амжилттай оролцож, БОШЛ-ын технологич инженер М.Чулуунхүү эмэгтэй дардасын төрөлд Мөнгө, жолооч Э.Бадрах ширээний теннисийн төрөлд Мөнгөн медаль тус тус хүргэж багийн дүнгээр тэргүүлэн “Шилжин явах цом”-ыг тус тус авсан.
3.	Ажлын байранд дасгал, хөдөлгөөнийг хийлгэж хэвшүүлэх	Жилдээ	Сарын ажил хариуцан ажиллаж байгаа хэлтэс, салбар, хэсгүүд ажлын өдрүүдэд 11 цагт ажлын байранд дасгал, хөдөлгөөн хийлгэх ажлыг зохион байгуулсан. Мөн “Өглөөний алхалт”-ын сарын аянд байгууллага хамт олноороо идэвхтэй оролцож 2 дугаар байранд шалгарлаа.

Товчилсон нэрийн тайлал :

МҮХ	Мэдээлэл, үйлчилгээний хэлтэс
ЦУОТХ	Цаг уур, орчны технологийн хэлтэс
ЗСААХ	Захиргаа, санхүү, аж ахуйн хэлтэс
ҮЭ	Үйлдвэрчний эвлэл

---oOo---